



ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН
ҮЙЛДВЭР ХХК-д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Арцатын 624, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2024.03.12 № 12/1114
танай _____-ны № _____-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**


Танай компаниас боловсруулж ирүүлсэн Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт хэрэгжих MV-010738 тусгай зөвшөөрлийн дугаартай "Төмөртолгойн төмрийн хүдрийн орд ашиглах" төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийн дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлнэ үү.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт 5 хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ц.УРАНЧИМЭГ

152400879

**ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧИГ
ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**


Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК, Дархан-Уул аймаг, Дархан хот, 16-р баг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн байр, Регистрийн дугаар: 2051303;

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 7555-0011;

Төслийн нэр: MV-010738 тусгай зөвшөөрлийн дугаартай "Төмөртолгойн төмрийн хүдрийн орд ашиглах" төсөл;

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт хэрэгжинэ.

Баримт бичгийн нэр	Шаардлагатай эсэх	Шаардлага хангасан эсэх	Тайлбар
Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/	Тийм	+	2024 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 02/414 тоот албан бичиг, /O77-2402-000170/
Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл	Тийм		MV-010738 тусгай зөвшөөрөл, АМГТГД-ын 2024.02.08-ний өдрийн т/13 тушаал, ЭБМЗ-ийн 2023.12.06-ний өдрийн т/23-20-01 дүгнэлт
Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/		-	
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	Үгүй		
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан	Тийм	+	"Маргад Очирваань" ХХК боловсруулсан.
Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын)	Тийм	+	
Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт	Тийм		Сумын засаг даргын 2023.11.30-ний өдрийн 1/649 дугаар албан бичиг.
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/	Тийм	+	Регистрийн дугаар: 2051303;
Уул уурхайн төслийн хувьд: А. Дээр дурдсан бүх баримт бичиг	Тийм	+	
Б.Тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар батлуулсан байх/	Тийм	+/	MV-010738

В. XV лицензтэй бол хайгуулын ажлын батлагдсан тайлан, нөөц баталсан шийдвэр	Тийм	/+/	MV-010738 тусгай зөвшөөрөл, АМГТГД-ын 2024.02.08-ний өдрийн т/13 тушаал, ЭБМЗ-ийн 2023.12.06-ний өдрийн т/23-20-01 дүгнэлт
Г. МV лицензтэй бол эрх бүхий байгууллагаар батлагдсан ТЭЗҮ, нөөц баталсан шийдвэр			
Д.БОНУ-ний нэмэлт, тодотгол хийлгэх төслийн хувьд нөөцийн хөдөлгөөний тайлан	Үгүй		
Е. Төсөлтэй холбоотой зураг төсөл	Үгүй		
Төсөлд ашиглах түүхий эд бэлтгэн нийлүүлэгчийн талаарх мэдээлэл г.м	Үгүй		
<p>Тусгай тэмдэглэл: “ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ийн төслийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэх шаардлагатай гэж үзлээ.</p>			
<p>Ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт, материалыг хянасан: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ШИНЖЭЭЧ</p>			
			 З.АЗЖАРГАЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

2024 оны 03-р сарын 07

Улаанбаатар хот

Дугаар 2024/АЗ-15

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК, Дархан-Уул аймаг, Дархан хот, 16-р баг, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн байр, Регистрийн дугаар: 2051303;

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 7555-0011;

Төслийн нэр: MV-010738 тусгай зөвшөөрлийн дугаартай "Төмөртолгойн төмрийн хүдрийн орд ашиглах" төсөл;

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт хэрэгжинэ.

Орон нутгийн санал: Сумын засаг даргын 2023.11.30-ний өдрийн 1/649 дугаар албан бичиг./E-Mongolia/ O77-2402-000170 дугаартай цахимаар ирүүлсэн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт зэргийг харгалзан үзэв.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Ний цсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар	
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох	
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм				
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	Хуулиар хоргилсон, хязгаарлсан газар байгаа эсэхийг нарийвчилсан үнэлгээний шатанд тодорхойлох	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм		
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх				Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар					
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх				Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх				Тийм	

	Усан орчин			
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм
	Хөрсөн бүрхэвч			
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм
	Ургамлан нөмрөг			
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм
	Амьтны аймаг			
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид			
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм
	Түүх, соёлын биет өв			
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл			
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм
	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм
Нэгдсэн дүгнэлт:				
Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны “Аргачлал батлах тухай” А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэн, нарийвчилсан үнэлгээний тайланг тус яаманд 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлж, шүүмж хийлгэн, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзлээ.				
Онцгойлон анхаарах зүйлс:				
1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хийлгэх бөгөөд олборлолтын технологийн дарааллыг нарийвчлан тодорхойлж, технологийн сонголтод үнэлэлт дүгнэлт өгөх;				
2.Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин /агаар, ус, хөрс, амьтан, ургамал г.м/-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг тооцож, нийлбэр үнэлгээг гарган уг төслийн экологи, эдийн засгийн үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;				

3. Тухайн орд газрын гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарал, уст үеийн хөдөлгөөн, тархалтыг олборлох технологитой уялдуулан нарийвчлан судалж, эрх бүхий байгууллагаар усны нөөцийн дүгнэлт гаргуулах;
4. Төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлын хэмжээ, түүний тархалт, нөлөөллийг хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;
5. Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг нарийвчлан тооцож, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тухай бүс нутагт орших эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх замаар биологийн олон янз байдлын амьдрах орчныг сэргээхээр саналыг боловсруулж, шаардагдах зардлыг тайланд тусгах;
6. УУХҮ-ын болон БОАЖ-ын Сайд нарын 2019 оны 8-р сарын 28-ны өдрийн А/181, А/458 дугаар тушаалаар батлагдсан "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын дагуу Ордын ашиглалт дууссаны дараах хаалтын нөхөн сэргээлт, мониторинг хийх төслийг боловсруулж, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог урьдчилан тооцож, тайланд тусгах;
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг тооцож ирүүлэх;
8. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах;
9. Уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн талаар болон эцэслэн боловсруулсан БОННҮ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих баг/хорооны ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсарган саналыг тусгах;
10. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхцалтай эсэх лавлагаа авч тайланд хавсаргах.
11. **Усны тухай хуулийн 22.1, 22.2, 22.3 дахь заалтыг мөрдөж ажиллах талаар тайланд тусгах;**
12. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн хүчин чадалд тулгуурлан мод тарих, модны төрөл зүйл, тоо хэмжээг тайланд тусгах;
13. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журмын 2.8. /Хэрэв тухайн төсөл нь хэд хэдэн баг, сумын нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих бол тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хуралд тус тусад нь танилцуулж санал авна./ гэж заасны дагуу хэрэгжүүлж ажиллах;
14. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн тайланд тусгах;
15. 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу нийгмийн нөлөөллийн үнэлгээг тооцох;
16. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн хүчин чадалд тулгуурлан мод тарих, модны төрөл зүйл, тоо хэмжээг тайланд тусгах;

Бусад зүйлс:

1. Ордыг ашиглах үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн Засаг захиргаа, байгаль орчны хяналтын улсын байцаагч болон холбогдох эрх бүхий байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх;
2. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаан хэрэгжүүлэх;
3. Төслийн хүчин чадал, техник, технологит өөрчлөлт орсон тохиолд ерөнхий үнэлгээнд тухай бүрт хамрагдаж шийдвэр гаргуулж ажиллах шаардлагатай болно.

Ерөнхий үнэлгээ хийсэн:

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖЭЭЧ**

Гарын үсэг:




З.АЗЖАРГАЛ

Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:
**"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР"
ХХК –ЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА**

Гарын үсэг:

Н.БАТБАЯР



"БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН"-ЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар № ДААТҮТӨХК/2023041759

2023 оны 09-р сарын 04-ний өдөр

Дархан-Уул аймаг

Нэг талаас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК РД:2051303 (цаашид "захиалагч" гэх) нь нөгөө талаас "Маргад очирваань" ХХК РД:6071317 (цаашид "гүйцэтгэгч" гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлтэйгөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх ажлын үнэ нь **32,000,000.0 [гучин хоёр сая]** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна. НӨАТ орсон үнэ болно.
2. Гэрээний үнийг гүйцэтгэгч "Маргад очирваань" ХХК-ийн харилцах Худалдаа хөгжлийн банкны 803002323, Голомт банкны 3635183474 дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл; /2023.08.24 01/1596/
 - 3.2. Гэрээ баталгаажуулах маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Техникийн тодорхойлолт; /Төмөртолгой уурхайн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тодотгол хийлгэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар /
 - 3.6. Ажлын хуваарь;
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг /эх/-ийн нэр: **Батжав**
Нэр: **Тулгацогт**
Албан тушаал: **Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга**
Ажлын утас: **75550011**
Гар утас: **88111600**
 - 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх/-ийн нэр: **Хүрлээ**
Нэр: **Мөрөн**
Албан тушаал: **Байгаль орчны мэргэжилтэн**
Ажлын утас: **75703344**
Гар утас: **80330021**
Цахим шуудан: expert@mro.mn

	(б) Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх үнийн дүн буюу 12,800,000 /Арван хоёр сая найман зуун мянган/ төгрөгийг гүйцэтгэгч нь гэрээт ажлыг бүрэн дуусгаж төрийн эрх бүхий байгууллагаар БОННУ тайланг баталгаажуулан Захиалагчид гэрээт ажлыг актаар хүлээлгэн өгсөн өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор төлнө.
ГЕН 5.1.	Урьдчилгаа төлбөрийн баталгаа: Үгүй Урьдчилгаа төлбөрийн баталгааны хэмжээ: Үгүй Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: Үгүй
ГЕН 5.2.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: Шаардахгүй
ГЕН 5.6.	Баталгаат хугацаа: <i>Баталгаат хугацаа шаардах эсэх: Шаардахгүй</i>
ГЕН 6.5.	Даатгал: Байхгүй
ГЕН 7.3.	Гомдлын шаардлага гаргах хугацаа: Үгүй Гомдлын шаардлага гаргах хугацаа:
ГЕН 9.17.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Үгүй Алдангийн хувь, хэмжээ:
ГЕН 9.18.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Үгүй Алдангийн хувь, хэмжээ:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК
ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

 Б.БАТАА

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

 Н.БАТБАЯР

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА

 Б.ТУЛГАЦОГТ

БОХАБЗЛА-НЫ ДАРГА

 Н.БАТЦЭНД

САНХҮҮ, НИЙТЛЭН БОДОХ БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.ЭНХЦЭЦЭГ

Утас, факс: 976-7555-0011

РД:2051303, УБД:1913013001

И-мэйл/Веб хуудас

info@dmp.mn, www.dmp.mn

Хаяг: Монгол Улс, Дархан-Уул аймаг

Дархан сум 16-р баг, өөрийн байр

Төв шуудан 906-р хайрцаг

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“МАРГАД ОЧИРВААНЬ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 Б.ЭРДЭНЭЖАРГАЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

 Х.МӨРӨН

Утас: 75703344, 80330021

РД: 6071317

Дансны дугаар: 803002323

Банкны нэр: Худалдаа хөгжлийн банк

Хаяг: Улаанбаатар, ХУД, 3-р хороо,

Хан-Уул тауэр 10 давхар, 1001 тоот

**ДАРХАН-УУЛ АЙМАГ, “ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ТӨХК-ИЙН
ТӨМӨРТОЛГОЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-010738/

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2051303/

АГУУЛГА

1. ТӨМӨРТОЛГОЙН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ...	6
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	9
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
5.2. Гадаргын ба газрын доорх усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
5.3. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
5.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
5.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	18
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
15. ТӨМӨРТОЛГОЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН 2024 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ЗАРДАЛ	21

1. ТӨМӨРТОЛГОЙН УУРХАЙН ТАНИЛЦУУЛГА

Ерөнхий мэдээлэл: “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-ийн 10738А тоот тусгай зөвшөөрөл бүхий Төмөртолгойн төмрийн хүдрийн ил уурхай нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт 2009 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Монгол Улсын Компанийн тухай хууль, Иргэний хууль, Төрийн болон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Манай уурхай нь байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөндөө уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖЯ-ны төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд (2011.07.20-ны № 6/2787) туссан болзошгүй болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллаж байна.

Ашиглалтын талбай: 424.09 га.

Нөөц: Төмөртолгой уурхайд одоогийн байдлаар зөвхөн баруун биет дээр олборлолтын /зүүн биетийн хүдэр олборлож дууссан/ үйл ажиллагаа явагдаж байна.

Байршил: Төмөртолгойн орд нь Монгол улсын хойд хэсэг дэх Хэнтийн нурууны дов толгодын бүсэд оршдог бөгөөд Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт, Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, Дархан-Уул аймгаас зүүн урагш 30 км зайд байрлана.

Ордын талбайн захын цэгийн солбилцол /WGS - 84/:

№	Зүүн уртраг	Хойд өргөрөг
1	106° 09' 42.21"	49° 18' 41.91"
2	106° 11' 22.21"	49° 18' 41.90"
3	106° 11' 42.21"	49° 17' 33.91"
4	106° 09' 42.21"	49° 17' 33.91"

Зам харилцаа: “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-иас Төмөртолгойн төмрийн хүдрийн ил уурхайн хооронд 28 км сайжруулсан шороон замыг 2011 онд ашиглалтанд оруулан ашиглаж байна. Тус замын арчилгааг байнга өөрийн тоног төхөөрөмжөөр засварладаг. Энэхүү замыг ашиглалтад оруулснаар Шарын гол болон Хонгор сумдын иргэд зорчихдоо газрын хөрсийг эвдэх, өөрсдийн дураар шинэ зам гаргах зэрэг байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагааг таслан зогсоосон.

Боловсон хүчин: 323 ажилчид 3 ээлжээр ажилладаг.

Цахилгаан хангамж: Эрчим хүчний дэд станцтай, төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон.

Усны хэрэгцээ: Гүний худаг ашигладаг. Технологийн усалгаанд гадаргын ус хуримтлуулах сангаас авч ашигладаг.

Дулаан хангамж: Хоолны газар, кемп, оффис, ахуйн болон операторын өрөөнүүдэд цахилгаан халаагуур ашигладаг.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уур амьсгал: Жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас бага, үүлшил, агаарын чийгшил багатай, эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг. Жилийн дундаж агаарын температур -0.6°C орчим байна. Дунджаар 247 орчим мм хур тунадас унах бөгөөд тууний 90.0 орчим хувь нь жилийн дулаан улиралд /4-9 дүгээр сарын хооронд/ орно. Төслийн бүс нутагт жилийн дундаж салхины хурд 1.7 м/с орчим, хаврын саруудын салхины дундаж хурд 2.4-2.5 м/с байдаг.

Агаарын чанар: Төмөртолгойн уурхайн үйл ажиллагааны үед агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх үүсвэр нь ил уурхайн олборлох болон хүдрийн баяжуулах үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт байна. "Дархан-Сэлэнгийн бүс нутагт Хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланд Төмөртолгойн уурхайн агаарын чанарт нөлөөлөх байдлыг 150 м зайд стандарт ($0.5\text{мг}/\text{м}^3$) - аас аль ч улиралд давж агаарын чанарт нөлөөлөх нөхцөлтэй гэж тусгасан байдаг. Хамгийн их бохирдуулагч эх үүсвэрт тооцогдох төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийн ойролцоох талбайд хэд хэдэн цэгт Дархан-Уул аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газрын Орчны шинжилгээний лабораторид хийсэн шинжилгээний дүнгээс үзвэл агаар дахь азотын давхар исэл / NO_2 /, хүхэрлэг хий / SO_2 /-н агууламж нь агаар орчны чанарын MNS 4585:2016 стандарттай харьцуулахад нэг удаагийн сорьц дахь бохирдлын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан тохиолдолгүй байв.

Гадаргын ус: Төмөртолгойн уурхайн талбай нь Орхон-Хараа голуудын ай савд орших ба Хэнтийн уулархаг мужийн баруун хойд хэсэгт хамрагдана. Усны гол хагалбарууд болох дунд зэргийн өндөрлөгтэй уул нурууд нь голын хөндийнүүдээс дээш дунджаар 200-400 м өндөрт өргөгдөж жалга, гангаар хэрчигдсэн тогтоцтой. Төмөртолгойн төмрийн ордын тусгай зөвшөөрөл бүхий талбай болон замын зурвас талбайн орчимд гадаргын усны нөөц байхгүй. Унд ахуйн болон уурхайн үйл ажиллагаанд хэрэглэх усыг газар доорх уснаас хангаж байна.

Газрын доорх ус: Төмөртолгойн уурхайн геологийн тогтоц нь нүх сүвийн болон ан цавын коллектор болох чулуулаг тархах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн нүх сүвийн ус агуулагч дөрөвдөгч галвын сэвсгэр хурдас нь элсэнцэр, хайрга дайрга, бул чулуу зэргээс тогтоно. Газар доорх ус 30 м-ээс илрэх ба хур тунадасны нэвчилт, ан цавын усаар тэжээгдэнэ. Ундрага 1л/сек орчим байна.

Усны нөөцийн хомсдол, барагдалт, чанарын өөрчлөлт: Төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар ялган авах тул үйлдвэрийн хэрэгцээнд ус бага хэрэглэгддэг.

Талбайн төв хэсэг Төмөртолгойн сайранд малтсан өрөмдмөл худаг нь ан цавархаг метаморф чулуулгийн уст давхаргад нэвтэрсэн. Худгийг 2009 онд 73м гүн өрөмдсөн. Усны ундарга 0.8л/сек, статик түвшин 20м. Ус нь гидрокарбонат-сульфат-кальци-натрийн найрлагатай. Жил бүр мэргэжлийн байгууллагаар усны химийн найрлага болон бохирын шинжилгээ хийлгэдэг ба шинжилгээний үр дүнд ус бохирдоогүй бөгөөд ундны усанд хэрэглэхэд бүрэн тохирч байна.

Уурхайн гүний худгийн усанд ашиглалтын хугацаанд хийгдсэн усны шинжилгээний дүнгүүдээс харвал худгийн ус нь химийн найрлагаараа гидрокарбонатын ангийн, натри калийн бүлгийн, I төрлийн цэнгэг зөөлөн ус байна. Уг усны шинжилсэн бүх үзүүлэлт нь МУ-ын "Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Унд ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ"-ний MNS 900:2005 стандартыг хангаж байгаа тул унд ахуйд хэрэглэхэд тохиромжтой байна.

Газар хөдлөл: "Таван үндэс" ХХК хуурай баяжуулах үйлдвэр ба барилгын зураг төслийн инженер геологийн судалгааг хийж гүйцэтгэсэн ба судалгааны талбай нь газар хөдлөлийн 72 баллд хамаарна.

Хөрсөн бүрхэвч: Төмөртолгойн орд орчмын нутаг нь хөрс газарзүйн муж, био-уур амьсгалын Хангайн их муж, өндрийн бүсжилтэй нутгийн Хэнтийн тойрогт багтана. Төмөртолгойн орд орчмын нутаг дэвсгэрт тархсан хөрсийг ялгаж тогтооход үндсэн дэд хэв шинжид хамрагдах хөрсүүд тархсан байна. Үүнд :

- Уулын хар хүрэн
- Уулын нимгэн хар хүрэн
- Хөнгөн шавранцар хар хүрэн
- Тариалангийн хар хүрэн
- Нугархаг хар хүрэн зэрэг хөрсүүд шавранцар, хөнгөн шавранцар зонхилсон механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний бохирдлын хувьд Лабораторийн задлан шинжилгээний дүнгээр шинжлүүлсэн элементүүдээс Со /Кобальт/-ийн агууламж нь "Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850:2008 стандарттай харьцуулан үзэхэд 1.04-1.6 дахин давсан бусад элементүүдийн агууламж нь хүлцэх агууламжаас даваагүй, ямар нэг бохирдолгүй хэвийн байна .

Ургамлан бүрхэвч: Уурхайн ургамлан нөмрөг уурхайн ухааш, баяжуулах үйлдвэр, зам тээврийн сүлжээ, барилга байгууламжийн талбайд бүхэлдээ дарагдах, хуулагдах байдлаар нөлөөлөлд өртсөн. Бэлчээрийн хэв шинжид бутлаг үетэн хялганат, алаг өвс-хялганат, үетэн-алаг өвст, хялгана-алаг өвст бүлгэмдэл зонхилж, зүйлийн бүрдлийн тоо 20-30, 1м² талбай дахь зүйлийн тоо 15-18 байв. Овоолго, зассан замын хажууг согоовор тарималжуулж нөхөн сэргээлт хийсэн. Үндсэн хялганат бүлгэмдэл нь түрэн орж ирж байгалийн аясаараа нөхөн сэргээгдэж буй ургамлан нөмрөгтэй байна .

Амьтны аймаг: Уурхайн талбай орчмын нутаг дэвсгэр Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалтаар уулархаг Азийн дэд их муж, Монгол Төвдийн мужийн Монгол дагуурын тойрогт хамрагдана. Амьтны аймгийн тархалтын судалгааг хөхтөн, шувуу, шавж гэсэн ангиллаар тодорхойлсон. Тухайн бүс нутаг нь хот суурин газарт ойрхон учир амьтны аймгийн томоохон төлөөлөгчид цөөн, сээр нуруугүйтэн амьтад, шувууд дунд зэрэг тархалттай, ядуувтар бүрэлдэхүүнтэй хээрийн бүсийн бодгалиуд тохиолдоно.

Нийгэм-эдийн засгийн төлөв байдал: Төмөртолгойн төмрийн хүдрийн ил уурхайн үйл ажиллагаа явагдснаар орон нутгийн төсөвт жилд 150 орчим сая төгрөгийн татвар төлөн, нөлөөлөлд өртөгч орон нутгийн иргэдээс жилд дунджаар 20 орчим ажилтнуудыг ажлын байраар ханган ажилладаг. Дархан-Уул аймгийн Хонгор сумын ЗДТГ, ИХТ-тэй хамтран үйл ажиллагааны жил жилийн төлөвлөгөө боловсруулан, харилцан зөвшилцөн батлан ажиллаж, жилийн эцсээр тайланг дүгнэн ажиллаж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төмөртолгойн уурхайн үйл ажиллагааны үед агаар, хөрс, ургамал, геологийн тогтоц зэрэгт ихээхэн нөлөөтэй байх боловч цаашдын үйл ажиллагааны үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох агаар, хөрс, ургамал болон газрын доорх ус зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг нөхөн сэргээлт, орчны тохижилт, аюулгүй ажиллагаа зэргийг сайтар төлөвлөн байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулбал эерэг тал нь их болох болно.

3.1. Газар болон хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хөрсний эвдрэл: Уурхайн хүдрийн ордыг ашиглах үед 15126 мян.м³ хөрс хуулж, 10366 мян.тн төмрийн хүдэр олборлоно. Ордын дундаж хөрс хуулалтын коэффициент 1.46 м³/тн байна. Ордын үйл ажиллагаар нийт 191.8 га талбай нөлөөлөлд өртөнө. Үүнд:

- Ил уурхайд 46.7 га талбай өртөх бөгөөд ашиглалтын төгсгөлд 160 м гүн, 1000 м урт, 520 м өргөн ухаш үүснэ.
- Баяжуулах хэсэг бусад барилга байгууламжид 11.4 га талбай өртөнө.
- Гадаад овоолгуудыг 98.8 га хийх бөгөөд зүүн овоолго 80.9 га, баруун хойд овоолго 10.7 га, баяжуулалтын хаягдлын овоолго 7.2 га талбайг эзэлнэ.
- Уурхайн технологийн замд 6.9 га, төмөр замын өртөө хүртэлх авто замд 28 га талбай өртөнө.

Өнгөн хөрсний бохирдолт: Уурхай нь бензин, дизель түлш, төрөл бүрийн тос тослох материал хүлээн авч хадгалах агуулах, тосолгоо үйлчилгээ, засварын үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр тос тослох материал, нефтийн бүтээгдэхүүнээр орчны хөрс бохирдох сөрөг нөлөө үзүүлнэ. Ашиглалтын явцад нийт 191.8 га талбайн газрын гадаргуу, үржил шимт өнгөн хөрс элэгдэл, эвдрэлд орно. Үүнээс илүү талбайг эвдрэлд оруулахгүй байхаар уурхайн дотоод үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд уурхайн дотоод үйл ажиллагаанд байгаль орчны асуудлыг БО инженер хянаж ажилладаг. Уурхайн үйл ажиллагаа болон түүний хог хаягдал тухайн газрын хөрсөн бүрхэвчинд нөлөөлж байгаа эсэхийг тогтоох зорилгоор хөрсний шинжилгээг авч хүнд металлын шинжилгээг "Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори"-оор хийлгэнэ.

3.2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Тоосжилтын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө: Ил уурхайн олборлолт болон баяжуулах үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн зорчих хэсэг, шаардлагагүйгээр удаан хугацаанд асаалттай байх механизм болон ил задгай хаясан хатуу болон шингэн хаягдлаас агаарын чанарт сөргөөр нөлөөлөх нөлөөлөл байж болно. Иймд дээрх асуудлууд дээр анхаарч агаарын чанарыг дээшлүүлэх үйл ажиллагааг менежментийн төлөвлөгөөнд тусган ажиллах болно.

Тоосжилтын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө: Тоосны том ширхгүүд (PM10) нь мөгөөрсөн ба гуурсан хоолойн салст бүрхүүлийг цочроож, халдвартай хавсран архаг ринит, ларингит, фарингит, транхет, бронхит үүсгэж болно. Уурхай болон баяжуулах үйлдвэрийн ажилчид ямар ажил гүйцэтгэж байгаа, тоосны найрлага зэргээс хамаарч антропокоз, силикоз, антракосиликоз гэсэн гурван төрлийн уушиг тоосжих өвчин тусч болно. Иймд ажилтнуудад амьсгал хамгаалах хэрэгслийг ажлын үргэлжлэх хугацаанд тогтмол хангаж ажиллана.

3.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төмрийн хүдэр ил аргаар олборлохдоо 6 жилийн хугацаанд 150-160м гүнд хүртэл олборлож уулын малталтанд шүүрэн орж ирсэн газар доорх урсацыг зумпээр зайлуулах тул газар доорх усны байгалийн горимд нөлөө үзүүлнэ.
- Уурхайн ахуйн бохир усыг цэвэршүүлэх байгууламж байхгүй. Шууд байгальд нийлүүлсэнээр гүний усанд бохирдлын нөлөө үзүүлэх магадлалтай. Иймд уурхайн ажилтнуудад зориулсан ил жорлонг био жорлонгоор сольж ажиллана.

3.4. Ургамлан нөмрөгийн чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаагаар ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг авч үзвэл ерөнхийдөө дунд зэргийн түвшинд байх ба биологийн төрөл зүйл устаж үгүй болох, сан хөмрөг хомсдож, нөөц багасах аюултай нөлөөлөл энд үгүй байна.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Төмөртолгойн уурхайн үйл ажиллагааны технологийн явцад Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБНҮ, байгаль орчны аудит, газрын чанарын хянан баталгаа болон мэргэжлийн хяналтын байгууллага, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудын заавар зөвлөмж, шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллахад оршино. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- БОНБНҮ-ний заалтуудыг хэрэгжүүлэх,
- “ДТҮ” ХХК-ний байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх,
- БОМТ-г хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох: Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй ААН, байгууллагуудын газар ашиглалтын үйл ажиллагаанд байгаль орчны хяналт тавих,
- Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах зэрэг багтана.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уурхайн дотоод гадаад замаас тоосжилт үүсэх	Зам талбайн тоосжилт дарах усалгааг тогтмол хийх	Уурхайн гадаад, дотоод зам талбай	-	-	Дотоод зардал		Хуурайшил ихтэй дулааны улиралд тогтмол хэрэгжүүлнэ	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 MNS 5014:2009 MNS 5013:2009
Тээврийн хэрэгсэлийн яндангаас гарах хорт хийгээр агаар бохирдох	Бүх тээврийн хэрэгсэлийг үзлэг оношлогоонд тогтмол хамруулан засварлах	Уурхайн ашиглалтын тээврийн хэрэгсэлүүд	-	-	Дотоод зардал		Үйл ажиллагааны турш	
Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотойгоор орчны тоосжилт нэмэгдэх	Өндөр даралтаар манажуулан ус шүршигч систем суурилуулах	Баяжуулах үйлдвэр	ш	1	Дотоод зардал		Жилд 1 удаа	
Нийт					Дотоод зардал			

5.2. Гадаргын ба газрын доорх усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Гүний худгийн ойр орчим бохирдох, усны чанарт өөрчлөлт орох	Гүний худгийн тоног төхөөрөмж, эрүүл ахуйн бүсийн арчилал, хамгаалалт	-	ш	1	Дотоод зардал		Тогтмол	Усны тухай хууль
	Худгийн байрны дотор талыг тогтмол цэвэрлэж ариутгал халдваргүйжүүлэлт хийж мөөгөнцөр үүсэхээс сэргийлэх	Гүний худаг	ш	4	Дотоод зардал		Улирал тутам	
Гүний усны нөөц багасах	Орчны тоосжилтыг бууруулахад шүүрлийн ус ашиглах	Төслийн талбай	га	-	Дотоод төлөвлөлт		Тогтмол	Усны тухай хууль
	Ус хэмнэгч хошууг уурхайн кемпийн гал тогоо, гар угаах хэсэгт суурилуулах	Ус хэмнэх менежмент	ш	2	50,000	100,000		
	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, гэрээ байгуулж төлбөр төлөх	Уурхай	-	-	Дотоод зардал		Жилд 1 удаа	Усны тухай хууль
Нийт					100,000			

5.3. Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөрс бохирдох, ургамлан нөмрөг талхлагдах	Тээврийн хэрэгсэлийг тогтоосон маршрутаар зорчуулах, хурдны хязгаар мөрдүүлэх, самбар байршуулах	Тээврийн зам	ш	1	Дотоод зардал		Жилд 1 удаа	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль, Газрын тухай хууль, MNS 5924:2015 MNS 5344:2011
	Био 00 байрлуулах	Баяжуулах үйлдвэр	ш	1	2,500,000		Жилд 1 удаа	
Шатах, тослох материалаар хөрсөн бүрхэвч бохирдох	Хаягдал ШТМ хадгалах сав хийх	Засварын газар	ш	1	Дотоод зардал		Жилд 1 удаа	
Ургамлан нөмрөг талхлагдах, зүйлийн бүрэлдэхүүн багасах	Ногоон байгууламж нэмж байгуулах	Цайны газар	М ²	100	Дотоод зардал		Жилд 1 удаа	
Нийт					2,500,000			

5.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Газрын хэвлий ашигласан төлбөрийг хугацаанд нь төлөөгүйгээс болж уурхайн үйл ажиллагаа хаагдах	Газрын хэвлийг ашигласан төлбөрийг хугацаанд нь төлөх	Уурхайн нийт талбай	га	424.1	Газар ашиглах гэрээний дагуу		-	Газрын хэвлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл
Нийт					Газар ашиглах гэрээний дагуу			

5.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уурхайн орчимд амьдардаг амьтад идэш тэжээлийн хомсдол орох	Өвөлжилт хүндрэлтэй үед амьтдад хоол тэжээлийн тусламж үзүүлэх	Төслийн талбай орчим	-	-	Дотоод зардал		Өвлийн улиралд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль
Хууль бусаар ан агнуур хийх	Ажилчид болон төсөлтэй холбоотойгоор төслийн талбайд ирэх хүмүүст хууль бус ан агнуурын тухай сануулга өгч, хууль тогтоомжийг танилцуулж ан агнуур хийлгэхгүй байх		-	-	Дотоод зардал		Тогтмол	
Нийт					Дотоод зардал			

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт	Зогсоолоор ашиглаж байсан талбай, гадна замыг нөхөн сэргээх	га	6,1	Дотоод төлөвлөлтөөр		Жилийн турш	-
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	Дархан Уул аймгийн нутагт мод тарих	ш	5000	5,000,000	5,000,000	Хавар, намар	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 4 дүгээр зүйл
Татан буулгах, хаалтад бэлтгэх	Хаалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулах	-	-	-	Дотоод зардал	Жилийн турш	-
Нийт					5,000,000		

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төсөл хэрэгжих хугацаанд уул уурхайн нөлөөнд өртсөн газар нутгийн биологийн олон янз байдлын хомсдол орох, алдагдах	Дүйцүүлэн хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхээр сонгон авсан газар нутагт техникийн нөхөн сэргээлт хийх	2023 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд үргэлжлүүлэн хийх (Цогт толгой, Хонгор сум)	3 га	3,000,000	-	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
	Тарвага нутагшуулах	Хонгор сумын нутагт	20	Дотоод зардал		
Нийт				3,000,000		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт суурьшиж буй иргэд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ явагддаггүй.

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
-	-	-	-	-	-	-	-
Нийт					-		

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төмөртолгойн уурхайд Улаанбаатар дээд сургуулийн Археологийн тэнхмээр түүх, палентлоги, археологийн судалгаа хийлгэсэн ба уурхайн ажилд өртөх түүх соёлын өвд хамаарах олдвор байхгүй гэсэн дүгнэлт гарсан. Гэвч уурхайн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвд хамаарах олдвор олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг зогсоож, мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж хамтран ажиллана.

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
-	-	-	-	-	-	-	-
Нийт					-		

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Газар хөдлөлт	Ажилчдын дунд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн үеийн авран хамгаалах сургалт зохион байгуулах, мэдээллийн самбар байршуулах	Нийт ажилчид	1	500,000		Жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
	Газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	1	Дотоод зардал	Байнга		
Хүчтэй шороон болон цасан шуурга	Гэнэтийн хүчтэй шороон болон цасан шуурга болоход байнгын бэлэн байдалд байж уурхайн талбайд ил задгай замбараагүй тоног төхөөрөмжийг байршуулахгүй байх	Уурхайн хэмжээнд	1	Дотоод зардал	Байнга		
Үер	Уурхайн ам, овоолго, барилга байгууламжийг үерийн усанд автахаас хамгаалах суваг шуудууг хур борооны эрчимжилтэй уялдуулан байгуулах	Уурхайн хэмжээнд	1			MNS AASHTO 86:2005	
Аянга цахилгаан	Дуу цахилгаантай бороо орох үед ажилчид, техник хэрэгслийн үйл ажиллагааг түр зогсоох						
Нийт				500.000			

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдал	Хог хаягдлыг ангилан ялгах	Уурхайн бүх ахуйн хог хаягдал	-	-	-	-	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
	Ахуйн хог хаягдлын цэгийг арчлах, битүүмжийг сайжруулах	Хогийн цэг	ш	4	Дотоод зардал		Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
	Ахуйн хог хаягдлыг орон нутгийн нийтийн аж ахуйн газартай гэрээ байгуулан, нийлүүлэх	Уурхайн бүх ахуйн хог хаягдал	рэйс	12	50,000	600,000	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
	Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх үүднээс бүх нийтийн цэвэрлэгээ хийх	Уурхайн орчин	удаа	24	Дотоод зардал		Долоо хоног тутам	Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлыг ангилан ялган дахин боловсруулагдах хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад нийлүүлэх	Уурхайн бүх хог хаягдал	-	-	Дотоод зардал		Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлын цэг, бохирын цооногт ариутгал хийх	Хог хаягдлын цэг, бохирын цооног	удаа	4	Дотоод зардал		Улирал тутам	Хог хаягдлын тухай хууль
Технологийн хог хаягдал	Технологийн хог хаягдлыг зам талбайн засварт дахин ашиглах	Уурхайн бүх технологийн хог хаягдал	рэйс	12	Дотоод зардал		5-10 сар	Хог хаягдлын тухай хууль
Аюултай хог хаягдал	ШТМ-ын хаягдал ангилан цуглуулах талбайд төмөр сав хийх	Уурхайн аюултай хог хаягдал	ш	1	Дотоод зардлаар		Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
	Аюултай хог хаягдлыг ангилан хадгалах, мэргэжлийн байгууллагаар зайлуулах, устгуулах	Уурхайн аюултай хог хаягдал	удаа	1	Дотоод зардлаар		Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
	Аюултай хог хаягдлыг төрөл дугаараар чанд бүртгэж, тайлан мэдээг тогтмол явуулж байх	Уурхайн аюултай хог хаягдал	-	-	Дотоод төлөвлөлтөөр		Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
	Орон нутгийн байгууллагатай гэрээ байгуулан эмнэлгийн хог хаягдлыг нийлүүлэх	Уурхайн эмнэлгийн хог хаягдал	удаа	4	120,000		Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
	Нийт				720,000			

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Цэгийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1. Агаар							
Тоосонцорын /PM2.5, PM10/ агууламж	Ил уурхайн орчим-2, Хөрсний овоолгын орчим-1, Хүдрийн овоолгын орчим-1, Баяжуулах үйлдвэрийн орчим-2, Хаягдлын овоолго-2, ТМ- агуулах- 1, Гадаад тээврийн замд-3	Жилд 3 удаа	12	50,000	1,800,000	-	MNS 4585:2016 MNS 3384:1982 MNS 4048:1988 MNS 5013:2009 MNS 5014:2000
Азотын давхар исэл NO ₂ , Хүхэрлэг хий SO ₂ , Нүүрстөрөгчийн дутуу исэл CO, CH ₄							
Дуу чимээ	Ил уурхайн орчим, Баяжуулах үйлдвэрийн орчим 1,2, Кемпийн талбай, Гадаад тээврийн замд		4	36,000	432,000		MNS 6768:2019
2. Хөрс							
Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд	Хогийн цэг, Кемпийн талбай, Баяжуулах үйлдвэр, Шимт хөрсний овоолго, Дотоод зам	Жилд 2 удаа, 5 болон 9 сард	5	85,000	425,000	-	MNS 3298:1991 MNS 5850:2019 MNS 3985:1987 MNS 3310:1991 MNS 2305:1995
Хүнд металлын шинжилгээ							
Хөрсний микробиологийн шинжилгээ							
3. Ус							
Ерөнхий хими, Микроэлемент, Бактериологийн шинжилгээ	Гүний худаг, Шүүрлийн ус, Ойр орчмын худаг	Жилд 2 удаа	3	150,000	450,000		MNS ISO 5667-1:2002 MNS ISO 5667-2:2002
Нийт					3,107,000		

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2023 он		
		Сар		
Тухайн жилийн БОМТ-г боловсруулж батлуулах, хэрэгжилтийг тайлагнах	Дотоод төлөвлөлтөөр	1-12сар	Байгаль орчны ахлах инженер	
- Байгаль орчин хамгаалах - Гал түймрээс урьдчилан сэргийлэх Хөдөлмөр хамгаалал зэрэг сэдвээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Дотоод зардал	1-12 сар	Байгаль орчны инженер	-
Үйлдвэрлэлийн зардлаар БО-ны тухай хууль, журам, стандартын биелэлтийг хангах зорилгоор дотоод хяналтыг зохион байгуулах	Дотоод төлөвлөлтөөр	1-12 сар	Байгаль орчны инженер	-
Уурхайн хаалтын төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэн батлуулах	Дотоод зардал	1-12 сар	Байгаль орчны инженер	
Нийт	Дотоод зардал			

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Дархан-Уул аймгийн БОАЖ-ын газарт	Хурал	Уурхайн үйл ажиллагаа, 2024 оны БОМТ-ний хэрэгжилт	2024/11	Дотоод зардал	Байгаль орчны инженер	Дархан-Уул аймаг, Дархан сум
Орон нутгийн иргэдэд	Өдөрлөг	Уурхайн үйл ажиллагаа, 2024 оны БОМТ-ний хэрэгжилт, хамтран ажиллах боломжийн талаар сурталчлах	2024/3, 2024/7	1,000,000	Байгаль орчны инженер	Дархан-Уул аймаг, Хонгор сум
БОАЖЯ-ны ХБОБНУ-ын газарт	Тайлан, төлөвлөгөө	Уурхайн үйл ажиллагаа, 2024 оны БОМТ-ний хэрэгжилт, 2025 оны БОМТ	2023/10-2024/01	Дотоод зардал	Байгаль орчны инженер	Улаанбаатар хот
Нийт				1,000,000		

15. ТӨМӨРТОЛГОЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН 2024 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН НИЙТ ЗАРДАЛ

№	Арга хэмжээ	Зардал, төг
1	Сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,600,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5,000,000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	500,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	720,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,107,000
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	1,000,000
Нийт		15.927.000